

Шүүхийн тухай хуулийн төслийн талаарх цуврал хэлэлцүүлэг №2

“Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгооны асуудал” хэлэлцүүлгийн тэмдэглэл

5 сарын 6, 2020

Өнөөгийн шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгооны байдал, шийдэх шаардлагатай асуудлын талаар:

П.Баттулга:

Эрх зүйт төрийг төлөвшүүлэх нь шүүхийн хараат бус байдлыг хангах замаар биелэгдэнэ. Эцсийн дүндээ шүүхийн хараат бус байдлыг хангах нь шүүгчийн томилгоотой шууд холбоотой байдаг. Шүүгчийн сонгон шалгаруулалт асуудлыг 1993 оноос 2012 он хүртэл гэж хувааж болно. 2012 онд Шүүхийн багц хууль батлагдсан. Энэ хуулийн хүрээнд Шүүгчийн сонгон шалгаруулалтад тодорхой хэмжээний өөрчлөлт орсон. 2012 он хүртэл Шүүгчийн сонгон шалгаруулахад голлох чиг үүрэгтэй оролцож байсан байгууллага бол Шүүгчийн мэргэжлийн хороо гэх бүтэц байсан бөгөөд Шүүгчийн мэргэжлийн хорооноос шалгалт авч тэнцсэн нэр дэвшигчдээс Шүүхийн Ерөнхий зөвлөл тодруулж Ерөнхийлөгчид санал болгох процессоор явж байсан.

2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд Шүүхийн Мэргэжлийн хорооны үнэлгээнээс гадна Монголын хуульчдын холбооны нэр дэвшигчийн мэдлэг ур чадварын талаар дүгнэлт гаргадаг болсон. Шүүхийн Ерөнхий зөвлөл нэр дэвшигчтэй ганцаарчилсан ярилцлага хийдэг шинэ зохицуулалт орж ирсэн. Шүүгчийн сонгон шалгаруулалтын арга ажиллагаа 10 удаа шинэчлэгдсэн батлагдсан, улам нарийн болж байгаа.

Маргаан дагуулдаг гол асуудал нь Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс нэр дэвшигчдийг Ерөнхийлөгчид санал болгох процесс нь тодорхойгүй гэх асуудал байдаг. Өндөр оноо авсан хүн шүүгч болоогүй, дараагийн өндөр оноо авсан хүн шүүгч болсон зэрэг маргаан их гардаг. Ойлгомжгүй байгаа учир зайлшгүй тодорхой болгох шаардлагатай байна. Одоогийн хэлэлцэж байгаа хуулийн төслөөс харахад хэд хэдэн зүйлийн хассан байна:

Ж нь: Монголын хуульчдын хорооны дүгнэлтийг гаргадаг процессын бүхэлд нь хассан байна. Мөн Шүүхийн Ерөнхий зөвлөл ярилцлага хийдэг процессыг бас хассан.

Шүүхийн Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг сонгох асуудал тодорхойгүй хэвээр байна.

2015 онд Анкетын судалгаа авч байсан. Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх процесс ажиллагаа ойлгомжгүй явагдаж байна уу гэх асуулгыг авахад 278 шүүгчийн 158 шүүгч санал нийлсэн.

2019 оны сүүлээр болон 2020 оны эхээр 275 шүүгчээс анкет судалгаа авсан. Сүүлийн 3 жилийн хугацаанд шүүгчийг анх томилохдоо тэдний мэдлэг туршлагаас гадна өөр шалгуураар томилох явдал гарсан гэдэгтэй санал нийлж байна уу гэх асуултад 48.29 хувь нь санал нийлсэн. 13.31 хувь нь санал нийлээгүй, 38.48 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Мөн Шүүхийн Ерөнхий зөвлөл шүүгчийн дээд шатны шүүхэд томилоход өөр шалгуураар томилсон гэж бодож байна уу гэх асуултад 45.90 хувь нь санал нийлсэн, 13.42 хувь санал нийлээгүй, 37.69 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан. Одоо хүртэл засагдаагүй байна гэдгийг харуулж байна.

Цаашид Монгол улсад Шүүгчийн хараат бус байдлыг дээшлүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлийг сонгох асуултад 59.64 хувь нь Шүүгчийг зөвхөн түүний мэдлэг туршлага, чадварт нь үндэслэн томилох асуудал гэж үзсэн.

Шүүгчийн мэдлэг, ур чадварт нь үндэслэн сонгон шалгаруулах асуудал маргаан дагуулж байгаа талаар Мерит бейс байдлаар хэрхэн зөв сонгон шалгуурлах асуудлын талаар:

О.Мөнхсайхан:

Иргэд маргаанаа шийдвэрлүүлэхээр эцсийн арга болгож шүүхэд ханддаг. Шүүхийн шийдвэр хүний амьдралын чухал шийдвэрийг эцэслэн гаргадаг. Иргэд шүүхэд хараат бусаар маргааныг зөв шийдвэрлэх итгэлийг хүлээлгэдэг. Тиймээс шүүгчийг олох асуудал хамгийн хэцүү. Шүүгч өндөр мэдлэг ур чадвартай, өндөр ёс зүйтэй, шударга хүн байх ёстой. Шүүгчийн сонгон шалгаруулалт нь төрийн алба дотор хамгийн мерит байдлаар явагддаг.

МУ-ын Үндсэн хуулийн 49.4-т зааснаар Шүүхийн Ерөнхий зөвлөл шүүгчдийг шилж олох чиг үүрэгтэй. Өнгөрсөн хугацаанд Шүүхийн Ерөнхий зөвлөл чиг үүргээ дангаараа бие даан хэрэгжүүлэх биш Мэргэшлийн хороог байгуулан, Мэргэжлийн хороо нь шалгалт авч, онооны эрэмбэ гаргаж, шалгалтад тэнцээгүй хүмүүсийг хасаж Шүүхийн Ерөнхий зөвлөлд өгдөг. Шүүхийн Ерөнхий зөвлөл Мэргэжлийн хорооны онооны эрэмбийг барихгүйгээр сонголт хийдэг. Үүнээс бол маргаан, шүүмжлэл гардаг.

Олон улсын хандалга бол Шүүгчийн сонгон шалгаруулах ажлыг зөвхөн 1 институт сайн хийж, шүүгчийн сонгох субъектэд өгөх ёстой. Манай улс шиг давхардсан институт ажиллаж байхад Мэргэжлийн хорооны шалгалтыг зөв бурууг Шүүхийн Ерөнхий зөвлөл үнэлж Ерөнхийлөгч руу явуулах болчхож байгаа юм. ҮХ-д заасан чиг үүрэг нь зөрчигдөнө. Шүүхийн Ерөнхий зөвлөл шалгалт авсан хүмүүсээс ахиад сонгоно гэхээр онооны эрэмбийг барихгүй байгаа талаар маргаан дагуулж байна.

Хууль зүйн дотоод хэргийн яамны өргөн барьсан төслөөр Мэргэшлийн хороо шалгалтаар эрэмбэлэхгүй, Ерөнхий хороо руу явуулж, Шүүхийн Ерөнхий зөвлөл сонголт хийх зарчим орж ирж байгаа. Ерөнхийлөгчийн барьсан төсөлд онооны эрэмбэ бол байгаа. Тэр маргаан тасрахгүй хэвээрээ байна гэсэн үг.

Мэргэшлийн хороог яаж бүрдүүлж байгаа юм? гэдэг нь маш чухал. Мэргэжлийн хороо Төсөлд шалгалтад тэнцэхгүй хүмүүсийг хасахаар байгаа.

Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс Мэргэжлийн хороо тусдаа байгуулагдвал Үндсэн хууль зөрчсөн хэрэг болно. Хууль зүйн дотоод хэргийн яамны төсөлд Мэргэжлийн хорооны гишүүдийн 6-г шүүгчдийн зөвлөл сонгоно. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн оролцоо байхгүй. Ерөнхийлөгчийн төсөлд Ерөнхий зөвлөл Хуульчдын холбооны санал болгосноор Мэргэшлийн хороог байгуулах, огцруулахаар байгаа. Заавал Хуульчдын хорооны санал

байх үгүй нь тусдаа асуудал. Гол томилгоо Ерөнхий зөвлөлд байх ёстой, үгүй бол Үндсэн хуулийн 49.4-н зөрчил рүү орох юм.

Энэ асуудлыг яаж шийдвэрлэх талаар судлаачийн байр суурь бол 2 төсөл дээр Ерөнхий зөвлөл яаж энэ хүмүүсээс сонгож шийдвэрлэх нь тодорхойгүй, олонхоороо сонгон гэсэн байгаа. Олонхоороо шийдвэрлэвэл мерит зарчимд харшилна. Энийг шийдвэрлэх ёстой. Нэр дэвшигчийн мэдлэг туршлага зэргийг шалгах ярилцлага хийх, ирсэн дүгнэлтүүдийг үндэслэн үндэслэл бүхий тайлан гаргаж байгаад нэр дэвшигчдийг сонгох зохицуулалт хийх, эсвэл Мэргэшлийн хороог татан буулгах ёстой. **Үндсэн хуулийн байгууллага биш, Үндсэн хуульд Шүүхийн Ерөнхий зөвлөл хийх ёстой гэж заасан ажлыг өөр байгууллагад өгөөд байгаа юм. Ялангуяа Мэргэжлийн хорооны гишүүдийн 3-ны 2-г Шүүхийн Ерөнхий зөвлөлийн оролцоогүй байгуулчихвал Шүүхийн Ерөнхий зөвлөлийн чиг үүргийг өөр институтэд өгсөн хэрэг болно.**

1-рт Үндсэн хуулийн чиг үүргийг Ерөнхий зөвлөлд нь өгөх,

2-рт Шүүхийн Ерөнхий зөвлөл өөрөө шалгаж, хамгийн сайн хүнээ нэр дэвшүүлэх ёстой.

Ерөнхий зөвлөлийн 10 гишүүнээ сайн сонгон шалгаруулж, 5 нь мэргэжлийн шүүгч байхаар болгоё, Шүүхийн Ерөнхий зөвлөл чиг үүргээ өөрөө хийсэн нь дээр.

Олон улсын зөвлөмж нь Мэргэжлийн хорооны онооны эрэмбийн дагуу сонгон шалгаруул эсвэл Мэргэжлийн хороог татан буулгаж Шүүхийн Ерөнхий зөвлөл өөрөө хийх ёстой. Мэргэжлийн хороо шийдвэрийг гаргаад байвал шүүгч нар шүүгч нарыг сонгох болоод байна. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр шүүгчид дангаараа шүүгч нарыг хэн байхыг шийдэхгүй гэх үзэл баримтлал байгаа.

Шинэ төслийн хуучин хуулиас ялгаатай зохицуулалтын талаар:

П.Сайнзориг:

Төслийн ажлын хэсэгт олон шийдэл яригдсан. Шүүгчийг сонгох, томилох асуудлын цаана Монгол улсын иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах гол баталгаа байгаа. Шүүгчдийг хэн сонгох нь ҮХ-ын зарчмаар тодорхой байгаа.

Шинээр шүүгчдийг яаж сонгон шалгаруулах, шат шатны шүүгчдийг шүүгчид хэрхэн яаж дэвшүүлэх асуудал, Шүүхийн ерөнхий шүүгчийг болоод танхимын шүүгчдийг хэрхэн томилох зэрэг бүлэг асуудлууд байгаа.

Төсөлд Мэргэжлийн хороо байх эсэх асуудал:

Онооны эрэмбийн асуудал, Мэргэжлийн хороог хэрхэн бүрдүүлэх талаар асуудал байгаа.

Монгол улсад хууль хэрэглээний жишиг стандарт тогтох эсэх асуудал шүүгч бүрдүүлдэг. Хууль хэрэглээний явцад ойлгомжгүй зүйл гарч хэсэг шүүгч нар, нөгөө хэсэг нь өөрөөр шийдвэрлэж байгаа учир үүнд цэг тавих ёстой.

Мэргэжлийн хороо олонхын саналаар байхаар зохицуулсан, Мэргэжлийн хороо нь Шүүхийн Ерөнхий зөвлөлийг дэмжин туслах чиг үүрэгтэйгээр байгуулсан. Шүүхийн Ерөнхий зөвлөл

10 гишүүнтэй байхаар болсон. Шүүгчийн мэдлэг, ур чадварыг шалгаж сонгож томилж байгаа. Шүүгч болсны дараа ч энэ институтийг ашиглах талаар шүүгчийн ёс зүйн хариуцлага болон мэргэжлийн процедурын ноцтой алдааг Мэргэжлийн хороогоор дүгнүүлэхээр байлгаж авч үлдэхээр болсон.

Онооны эрэмбийн хувьд:

Мэргэжлийн хороо шүүгчдийн суурь болон тусгай шалгалтыг зохион байгуулахаар зохицуулсан. Онооны эрэмбээр гаргахаар маргаан гарч ирсэн. Шүүгчийн сонгох асуудал нь мэдлэг ур чадварыг шалгахдаа гол нь биш, нөгөө талдаа шүүгч болох хүний ёс зүй, хандлага зэргийг авч үзэх шаардлага байгаа. Тиймээс Мэргэжлийн хороо шалгаж тэнцсэн, тэнцээгүй гэдгийг гаргаж Шүүхийн Ерөнхий зөвлөлд танилцуулахаар байгаа.

Нэр дэвшигчийн дүгнэлт авах зохицуулалт байгаа. Төслийн 89.6-д нэр дэвшигчийн мэргэжил ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг авах журмыг Шүүхийн Ерөнхий зөвлөл батлахаар заасан байгаа.

Ерөнхийлөгчийн өргөн барьсан төслийн одоогийн хуульд байгаа зохицуулалтаас ахиц дэвшил гарсан гэж үзэж буй зохицуулалтын талаар:

Л.Галбаатар:

Хуулийн төсөлд Шүүгчийн томилохтой холбоотой асуудлыг боловсруулахдаа баримтлах хэд хэдэн зүйлсийг гаргаж ирсэн. МУ-ын ОУ-н гэрээнд заасан үүргээ биелүүлэе, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг харгалзъя гэсэн байдлаар зохицуулсан.

Монгол улсын Олон улсын гэрээ гэдэгт:

1969 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. Энд шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаажуулсан байгаа. Шүүгчийн сонго шалгаруулалт, томилгооны цаана иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийн асуудал байдаг.

1985 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гаргасан Шүүхийн бие даасан байдлын үндсэн зарчмуудын 10 дугаар зүйлд шүүгч ямар байх ёстой шалгуурыг зааж өгсөн. Өндөр ёс суртахуунтай байх ёстой, мэргэшсэн байх ёстой, туршлагатай байх ёстой гэсэн 3 шалгуурыг хангасан хүнийг хэрхэн шилж олох вэ гэсэн асуудал байгаа.

Хууль бус сэдэлтээр шүүгчийн томилохгүй байхыг баталгаажуулсан байх ёстой гэсэн зарчим байгаа.

Үндсэн 5 агуулгыг төсөлд тусгасан. Мэргэжлийн хороог 9 гишүүнтэйгээр байгуулах зохицуулалтыг хэвээр хадгалсан. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн чиг үүрэг хэдий ч мэргэжлийн хяналт байх ёстой гэдэг утгаар хэвээр үлдээсэн. Мэргэжлийн хорооны гишүүдийг Хуульчдын холбооноос санал болгоход нэр дэвшиж байгаа хуульчдын талаар Шалгалтын хорооны дүгнэлт гаргаж, Хуульчдын хорооны зөвлөлд санал болгож зөвлөлийн 48 гишүүний олонхын саналаар баталгуулдаг байгаа. Шүүгч нарын ёс суртахууны шалгуурыг хөндлөнгийн институт дүгнэх ёстой.

Ерөнхийлөгчид санал болгох шийдвэрийг урьдчилан Шүүхийн Ерөнхий зөвлөл гаргаж байгаа. Одоогийн зохицуулалтаар Ерөнхий зөвлөлийн гишүүд саналаа илээр гаргахаар

байгаа. Илээр гаргана гэдэг нь нөлөөлөх боломжтой учир нээлттэй хэлэлцэж, саналаа нууцаар өгөх зохицуулалт оруулсан.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг Ерөнхийлөгч авснаас 14 хоногийн дотор томилно гэж заасан. Ерөнхийлөгч томилохоос татгалзах үндэслэл байвал Шүүхийн Ерөнхий зөвлөлд албан ёсоор мэдэгдэх ёстой гэсэн зохицуулалт орсон байгаа.

П.Сайнзориг:

Томилгооны асуудлын талаар

ҮХ-ын суурь зохицуулалттай зохицох ёстой. ҮХ-ийн 51.3 дугаар зүйл

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн санал болгосон нь шаардлага хангаагүй байна гэж үзвэл Шүүхийн Ерөнхий зөвлөлд албан бичгээр мэдэгдэх ёстой. Шүүхийн Ерөнхий зөвлөл энэ асуудлыг шалгаж үзээд үндэслэлтэй байна гэж үзвэл дараагийн нэр дэвшигчийг санал болгох гэх мэт асуудал яригдана. Ерөнхийлөгчийн гаргасан үндэслэл тогтоохгүй бол дахин санал болгохоор зохицуулсан.

Цаашдаа Монгол улсын Ерөнхийлөгч гэх институтийг үнэт зүйлийнх нь хүрээнд ажиллуулах үүднээс хуульд зааснаас бусад эрх мэдлийг шилжүүлэхгүй байх бодлого бүх түвшинд явж байгаа. Үүнийг харгалзаж

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг томилохоос бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох асуудлыг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөл дээр өөрөөр авч үзсэн. Тухайн шүүгчдийн зөвлөгөөнөөс шүүгчид нь дотроосоо ерөнхий шүүгчээ 3 жилийн хугацаагаар сонгож, нэг удаа улируулан томилох боломжтойгоор зохицуулъя. Ерөнхий шүүгч нь өдөр тутмын зохион байгуулалтын үүрэгтэй байдаг учир шүүгч нар дотроосоо сонгох зохицуулалтыг дэмжиж байгаа. Танхимын тэргүүний асуудлыг Ерөнхий шүүгч шийдвэрлэхээр зохицуулсан.

Өмнө нь Ерөнхийлөгч санал хүлээн авсан ч үндэслэлгүйгээр татгалздаг тохиолдолд байдаг байсан. Нэр дэвшигч хохирдог байсан. Шүүхийн Ерөнхий зөвлөл ажиллаж чадаж байгаа эсэх, Ерөнхийлөгч үндэслэлгүй татгалзсан эсэх асуудлаар үл ойлголцол гардаг байсан.

Л.Галбаатар:

Шүүгчийн томилох эрх Ерөнхийлөгчид байгаа. Шүүгчийг томилох эрхийн цаана баталгаажуулах гэдэг ойлголт байгаа гэдэг үүднээс хандсан. Ерөнхийлөгчийн төсөл дээр шүүгчийг сонгон шалгаруулах журмыг Шүүхийн Ерөнхий зөвлөл Мэргэжлийн хороотой хамтран батлахаар заасан байгаа. Мөн баталгаажуулах хугацааг нь тодорхой болгосон. 14 хоногийн хугацаанд заавал томилох үүрэг хүлээлгэсэн байгаа. Одоогийн зохицуулалтаар томилох, томилохоос татгалзаж болох зохицуулалт байгаа бол Үндсэн хуулиар үүрэг хүлээсэн байгууллага нь санал болгосон бол аль болох татгалзахгүй батлах, татгалзах бол албан ёсоор саналаа хүргэх ёстой гэсэн зохицуулалт орсон байгаа.

Асуулт: Ерөнхийлөгчийн өргөн барьсан төсөлд Ерөнхий шүүгчийг сонгохтой холбогдсон зохицуулалтыг ямар учраас хэвээр нь үлдээсэн бэ?

Л.Галбаатар: Үндсэн хуульд шүүгчийг томилно гэж заасан учир шүүгчийн сонгоно гэсэн ойлголт байхгүй. Шүүгч шүүн таслах гол үйл ажиллагааг хийх ёстой байтал дотроо сонгууль явуулах, хооронд нь талцуулах ёсгүй. Шүүх дотор сонгууль явуулах биш, томилогдох ёстой гэж үзсэн.

Шүүгчийн томилгоотой холбоотой ямар санал зөвлөмж байна вэ?

О.Мөнхсайхан:

Хууль зүйн яамны төслийн хугацааны асуудал, татгалзах үндэслэлээ заах, үндэслэл нь бодит эсэхийг Шүүхийн Ерөнхий зөвлөл шалгаж, бодит биш бол дахин санал болгох зохицуулалт орсон нь сайшаалтай. Шүүгчийн томилно гэж Үндсэн хуульд заасан. Томилно гэдэг нь үүрэгжүүлсэн утгатай. Сүүлийн жилүүдэд Ерөнхийлөгч үзэмжээрээ татгалзах асуудал их байсан. Ерөнхийлөгч зүй бус нөлөөнд орох асуудлыг саармагжуулах зохицуулалт чухал байна. Дээд шүүхийнхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох уу, сонгох уу энэ талаар Үндсэн хуульд ямар ч зохицуулалт байхгүй. Энийг хууль тогтоогч шийднэ. Дээд шүүхийн шүүгчээс бусад ерөнхий шүүгчийн томилох эрх Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар олгогдоогүй. Хууль зүйн яамны төсөл энэ талаараа маш сайн байна. Дээд шүүхийн шүүгчээс бусад ерөнхий шүүгчийн томилох эрх Ерөнхийлөгчид өгвөл Үндсэн хуулийн 33.4-г зөрчинө. Шүүгчийн томилгооны эрх мэдлийг нэг субъектэд хамаатай болгох нь аюултай.

Үндсэн хуулиар Ерөнхийлөгч Дээд шүүхийн ерөнхий шүүгч болон шүүгчдийг л томилох эрхтэй. Бусад бүх шүүхийн ерөнхий шүүгчдийг сонгох эрх хэмжээг өгөхөөр эрх мэдэл төвлөрч, зүй бус нөлөөнд ордог гэх маш олон судалгаа байгаа. Үндсэн хуулиар шүүгчийг томилж байгаа, томилогдсон шүүгчдийн хэнийг ерөнхий шүүгч хийх вэ гэдгийг дотроосоо сонгох нь хамгийн сайн хувилбар.

Шүүхийн ерөнхий зөвлөл, Мэргэжлийн хорооны шалгаруулалтад Ерөнхийлөгч орох нь Үндсэн хуулиар хориотой. Сонгон шалгаруулалт Ерөнхийлөгчөөс хараат бусаар явах ёстой. Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг авч Ерөнхийлөгч томилох л эрхтэй.

Монгол улсын Шүүхийн тухай хуульд өгөх санал, шүүмжийн талаар хэлэх санал хүсэлт байна уу?

П.Баттулга:

Улсын Дээд Шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг дотроосоо сонгохыг дэмжиж байгаа. Бусад шүүхийн Ерөнхий шүүгчийн хэрхэн томилохыг үндсэн хуулиар зохицуулаагүй. 2013 оноос хойш 3 жилээр томилох, нэг удаа улируулан томилохоор ялгаатай зохицуулж байсан. Ерөнхий шүүгчийг шүүх дотроосоо сонгох нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх боломжгүй. Хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал. Шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүхээ төлөөлөх, шүүгчийн бие даасан байдлыг хангах, шүүгч нартаа хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой учир дотроосоо сонгох боломжтой юм. Ерөнхийлөгч томилохоос татгалзсан саналаа үндэслэлтэй тайлбарлах талаарх зохицуулалттай санал нэг байгаа.

Үндсэн хуулийн 49.4-т байгаа Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн үүргийг оновчтой тайлбарлах ёстой. Шилж сонгох гэдэг нь дараах утгатай. 1-рт Үндсэн хуульд зааснаар Шүүхийн Ерөнхий

Зөвлөл сонгож Ерөнхийлөгчид санал болгох нь тодорхой. Ямар аргачлалаар үнэлэх журам нь тодорхой байх ёстой. Шүүгчид сонгон шалгуулах журмыг Шүүхийн Ерөнхий зөвлөл баталж ирсэн. 2013 оноос хэрэгжсэн хуульд Сонгон шалгаруулах журмыг Ерөнхийлөгч батална гэхдээ Шүүхийн Ерөнхий зөвлөлийн боловсруулснаар гэсэн байсан. Шүүхийн ерөнхий зөвлөл үнэлгээг хэрхэн хийх эсвэл хороо байгуулж хийнэ.

Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө шалгах боломжгүй байсан. Шүүхийн ерөнхий зөвлөл сонгож томилон, хянах онооны эрэмбийг барихгүй байх нь үндэслэл муутай юм. Мэргэжлийн хүмүүсийг ажиллуулж онооны эрэмбээ баримтлах нь зүйтэй.

Одоо шүүхийн сонгон шалгаруулалтууд зарлагдсан байгаа. Яаж сонгох дээр бас л маргаан гарна.Тиймээс нэр дэвшигчдийг яаж сонгох нь тодорхой байх ёстой. Онооны эрэмбийн асуудал дээр бид шалгалтаар өндөр оноо авсан 3-с нэгийг нь сонгох арга санал болгосон байгаа.

П.Бадамрагчаа:

Хүмүүсийн санал:

- Процедур тодорхой байх ёстой
- Шүүхийн практик, туршлагатай хүмүүс орж ирэх шаардлагатай байна.

Хэлэлцүүлгээр 2 асуудлыг голлож ярилцсан:

1.Шүүгчийн сонгон шалгуулах асуудалд Мерит бейс зарчимд тулгуурласан сонгох зохицуулалтыг оруулах ёстой. Хэрхэн сонгогдож байгаа нь хардлага сэрдлэг бий болгож буй нь шүүхэд итгэх итгэлийг үгүй болгож байна. Сонгон шалгаруулалт явуулж буй субъектүүдийн чиг үүргийн давхардал, ойлгомгүй байдлыг тодорхой болгох шаардлагатай байна гэж үзлээ.

2.Шүүгчийн томилгооны талаарх асуудалд томилох эрх хэмжээний төвлөрлийг саармагжуулсан буюу бүх шатны шүүгчид, ерөнхий шүүгчид, танхимын тэргүүнүүдийг томилох болон эдгээрийг сонгон шалгаруулах бүрэлдэхүүнийг томилж байсан эрх хэмжээг саринуулсан зохицуулалт орсныг хууль тогтоогчид цааш нь авч явах шаардлагатай юм.